



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар A/100

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захирагаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 28.1.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захирагааны өрөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VIII хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын 2022 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө болон тухайн сумын Засаг даргын санал, Хөвсгөл аймгийн тавдугаар цэцэрлэгийн хүсэлтийг тус тус үндэслэн Мөрөн сумын 3 дугаар баг, тавдугаар цэцэрлэгийн урд талд байршилтай боловсролын байгууллагын зориулалттай 1559м<sup>2</sup> газрыг Хөвсгөл аймгийн тавдугаар цэцэрлэг (РД:9070249)-т 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа Хөвсгөл аймгийн тавдугаар цэцэрлэг /РД:9070249/-тэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзүл) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

